

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2007 оны 2 дугаар сарын
2-ны өдөр

Дугаар 19

Улаанбаатар хот

Хувьцааны арилжаанаас авах хураамжийн
дээд хязгаарыг шинэчлэн тогтоох тухай

“Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай” хуулийн 6.1.2 дахь заалт, “Үнэт цаасны зах зээлийн тухай” хуулийн 34.1.12 дахь заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Улаанбаатар хот, Дархан-Уул аймгийн Дархан сум /Дархан хот/, Орхон аймгийн Баян-Өндөр сум /Эрдэнэт хот/-нд байршил бүхий брокер, дилерийн компани хувьцааны арилжаанаас авах үйлчилгээний хураамжийн дээд хязгаарыг тухайн арилжааны үнийн дүнгийн 4.5 хувиас, бусад хөдөө орон нутагт байршил бүхий брокер, дилерийн компанийн авах үйлчилгээний хураамжийн дээд хязгаарыг тухайн арилжааны үнийн дүнгийн 6 хувиас тус тус ихгүй байхаар бууруулж тогтоосугай.

2. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулж Үнэт цаасны хороо /хуучнаар/-ны 1998 оны 4 дүгээр сарын 16-ны өдрийн “Монголын хөрөнгийн биржийн үйлчилгээний зарим хураамжийн талаар авах арга хэмжээний тухай” 41 тоот тогтоолын 2,3 дахь заалт, Үнэт цаасны хороо /хуучнаар/-ны 1997 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн “Үйлчилгээний хураамжийн талаар санал болгох тухай” 33 тоот тогтоолын 1 дэх заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

3. Энэхүү тогтоолын 1 дэх заалтаар тогтоосон хураамжийн дээд хязгаарыг холбогдох дүрэм, журам, програмд тусгаж, мөрдөж ажиллахыг “Монголын хөрөнгийн бирж” ХК /Р.Содхүү/, “ҮЦТТТХТ” ХХК /Т.Гандулам/ болон брокер, дилерийн компанийн удирдлагуудад тус тус үүрэг болгосугай.

4. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд сурталчилж ажиллахыг Ажлын алба /О.Ганбат/-нд даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН